

АЮУЛГҮЙ АМЬДРАХ УХААНЫ БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ НЬ

DEVELOPING THE ACTIVITIES ON LIVING SAFETY EDUCATION IN MONGOLIA

УЛУЧШЕНИЕ ДЕЯТЕЛЬНОСТИ ВЫДАЧИ ОБРАЗОВАНИЯ ПО БЕЗОПАСНЫМ ЖИЗНЕННЫМ НАВЫКАМ



Д.СЭРЖМЯДАГ

ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэнгийн
Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D), хошууч
SERJMYADAG D.

Scientific secretary for Institute of Disaster Studies under
the National Emergency Management Agency (Ph.D), Major

Д.СЭРЖМЯДАГ

Институт исследования бедствий при ГУСЧ,
ученый секретарь, кандидат менеджмента, майор ЧС

Товч утга: Ерөнхий боловсролын сургуульд аюулгүй амьдрах ухааны боловсролыг олгож буй арга хэлбэрийг шинжилж, цаашид түүнийг сайжруулах, үр дүнтэй хэлбэрээр хүргэх арга замыг дэвшүүлэх зорилго тавьсан. Энэ хүрээнд Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүргийн байгууллагууд хүүхэд, өсвөр үеийнхэнд аюулгүй амьдрах ухааны боловсрол эзэмшүүлэх, эх оронч сэтгэлгээг хөгжүүлэх чиглэлээр явуулж буй үйл ажиллагаагаа нэгтгэх, түншлэх нь ихээхэн чухал байгааг тодорхойллоо.

Abstract: This study is aimed to consider that how to develop the activities on Living Safety Education in schools of Mongolia. There are two types of Living Safety Education curriculum such as formal and extra curriculum. The education system in Mongolia has not included Living Safety Education in formal school curriculum. As a result of the research, certain proposals for raised for develop the activities on Living Safety Education in schools using by extra curriculum.

Түлхүүр үгс: Аюулгүй амьдрах ухааны боловсрол, албан ба албан бус сургалтын хөтөлбөр.

Key words: living safety education, curriculum and extra curriculum.

Аюулгүй амьдрах, эрсдэлгүй аж төрөх боловсрол эзэмших нь хүний амьд явах, аюулгүй орчинд амьдрах язгуур эрх ашгаар илэрхийлэгдэнэ. Монгол Улсын Үндсэн хуулинд “Монгол Улсын иргэн нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй” хэмээн тунхагласан байдаг. Ийм ч учраас манай улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүрээнд баталсан хүний эрхийг дээдлэх, аюулгүй орчныг бий болгохтой холбоотой олон улсын гэрээ, конвенц, бодлогын баримт бичигт нэгдэн орж энэ талаар олон улсад үүрэг хүлээж, төрийн зүгээс олон ажлыг хийж хэрэгжүүлж ирсэн.

Хүн амдаа аюулгүй амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх талаар төрийн явуулж буй бодлого, үйл ажиллагааг бодит ажил хэрэг болгоход хувь хүний зан төлөв, хандлага, оролцоо амин чухал. Энэ утгаараа аюулгүй амьдрах ухааны боловсролыг хүүхэд, өсвөр үеийнхэнд эзэмшүүлэх нь энэ чиглэлээр хийх анхдагч буюу нэн

тэргүүний ажил юм.

Энэхүү судалгаанд ерөнхий боловсролын сургуульд аюулгүй амьдрах ухааны боловсролыг олгож буй арга хэлбэрийг шинжилж, цаашид түүнийг сайжруулах, үр дүнтэй хэлбэрээр хүргэх арга замыг дэвшүүлэх зорилго тавьсан. Энэ хүрээнд Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүргийн байгууллагууд хүүхэд, өсвөр үеийнхэнд аюулгүй амьдрах ухааны боловсрол эзэмшүүлэх, эх оронч сэтгэлгээг хөгжүүлэх чиглэлээр явуулж буй үйл ажиллагаагаа нэгтгэх, түншлэх нь ихээхэн чухал байгааг тодорхойллоо.

Аюулгүй амьдрах ухааны боловсрол олгож буй өнөөгийн байдал

Дэлхийн улс орнууд албан ба албан бус хөтөлбөр (хичээлээс гадуурх нэмэлт хөтөлбөр)-өөр аюулгүй амьдрах ухааны боловсролыг олгож байна.

НҮБ-ын Хүүхдийн сан болон НҮБ-ын ЮНЕСКО нь улс орнууд боловсролын тогтолцоондоо аюулгүй амьдрах ухааны боловсрол олгох хөтөлбөрийг хэрхэн оруулсан байдалд шинжилгээ хийжээ.¹ Уг судалгаанд хамрагдсан 30 орны туршлагаас харахад албан сургалтын хөтөлбөрийн хувьд олон төрлийн хичээлийн хөтөлбөрт гамшгаас хамгаалах, аюулгүй амьдрахтай холбоотой сэдвийг багтаах замаар боловсрол олгох хандлага хамгийн түгээмэл байна.

Зураг 1. Дэлхийн улс орнуудад аюулгүй амьдрах ухааны мэдлэгийг бусад хичээлийн хөтөлбөрт нэгтгэж олгох байдал



Хэдийгээр аюулгүй амьдрах ухааныг холбогдох олон төрлийн хичээлийн хөтөлбөрт багтаан орж байгаа ч эдгээр хөтөлбөрүүд хоорондын хэвтээ чиглэлийн буюу хичээл хоорондын уялдаа холбоо хангалтгүй байгаа тул хүүхдүүдэд цогц мэдлэг, чадвар, хандлагыг олгож чадахгүй байна. Мөн түүнчлэн хөтөлбөрүүдийн босоо залгамж холбоо буюу хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт нийцэж мэдлэгийн хүрээ гүнзгийрэх байдал хангалтгүй байгааг уг судалгаанд дурджээ. Иймд аюулгүй амьдрах ухааны боловсролыг бие даасан хичээл хэлбэрээр сурагчдад олгох нь хамгийн үр дүнтэй байх бөгөөд ийм хандлагыг одоогоор ОХУ, Беларусь, Япон зэрэг улс орнууд хэрэгжүүлж байна.

Монгол Улсын хувьд аюулгүй амьдрах ухааны боловсрол олгох асуудлыг "Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого"-ын баримт бичигт "...хүн амыг аюулгүй амьдрах ухаанд сургах..." гэж, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т "Гамшгаас хамгаалах сургалтыг удирдах албан тушаалтны; аврах анги, отряд, салбар, мэргэжлийн ангийн; оюутан, сурагчдын; ажилтны; бусад

¹ Disaster Risk Reduction in School Curricula: Case Studies from Thirty Countries, UNICEF, 2012

иргэний гэсэн ангиллаар явуулна” гэж заасан. Энэ хүрээнд ОБЕГ-ын даргын 2007 оны 2 дугаар сарын 9-ны 81 дугаар тушаалаар батлагдсан Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролоор сурагчдын судлах “Аюулгүй амьдрах арга ухааны үндэс” хичээлийн хөтөлбөр мөн “Ерөнхий боловсролын сургуульд иргэний хамгаалалтын сургалт явуулах журам”-ыг тухайн үеийн Шинжлэх ухаан боловсролын яамны сайд, Улсын иргэний хамгаалалтын газрын дарга 1995 оны 115/110 дугаар хамтарсан тушаалаар баталж, 9 дүгээр ангид 21 цагийн хичээл үзэх хөтөлбөрүүд гарсан байдаг ч энэ нь бүрэн утгаараа хэрэгжихгүй өнөөдрийг хүрчээ. Өөрөөр хэлбэл, өнөөдрийг хүртэл аюулгүй амьдрах ухааны боловсрол олгох сургалт ерөнхий боловсролын сургуулийн албан ёсны сургалтын хөтөлбөрт ороогүй байна.

Ерөнхий боловсролын сургуульд аюулгүй амьдрах ухааны боловсролыг хичээлээс гадуурх нэмэлт хөтөлбөрөөр олгох үйл ажиллагаа нь сурагчид өөрсдийн сайн дурын үндсэн дээр нэгдэж клуб, дугуйлан хичээллүүлэх, уралдаан тэмцээн зохион байгуулах хэлбэрээр явагддаг.²

Өнөөдөр манай улсад аюулгүй амьдрах ухааныг сурагчдад хичээлээс гадуурх нэмэлт хөтөлбөрөөр эзэмшүүлэх үндсэн хэлбэр бол “Өсвөрийн аврагч” бүлгийг хичээллүүлэх явдал юм.

“Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд Өсвөрийн аврагч клуб/дугуйлан хичээллэх боломж”-ийг тодорхойлох судалгаанаас харахад (судалгаанд 7 аймаг, Улаанбаатар хотын нийт 216 сургуулийн багш, нийгмийн ажилтан хамрагдсан) санал асуулганд оролцсон нийт сургуулийн дөнгөж 10 хувьд нь энэ бүлэг хичээллэдэг байна. Харин нийт санал асуулгад хамрагдсан сургуулийн 80 гаруй хувьд нь “Эко” клуб, 50 гаруй хувьд нь “Өсвөрийн улаан загалмайч”, “Өсвөрийн цагдаа” клубүүд хичээллэдэг байна (1-р хүснэгт).

Харин Танай сургуульд Өсвөрийн аврагч бүлэг байгуулах хэрэгцээ, шаардлага бий юу? гэсэн асуултанд асуулганд оролцогсодын 90 шахам хувь нь тийм гэж хариулснаас үзвэл гамшгаас хамгаалах, аюулгүй амьдрах боловсрол олгох хэрэгцээ зайлшгүй байгааг харуулж байна.

1-р хүснэгт. Ерөнхий боловсролын сургуульд сурагчдын
сайн дурын үүсгэлд үндэслэн хичээллэдэг клуб/дугуйлан³

№	Аймаг	Оролцсон сургуулийн тоо	Сурагчдын сайн дурын үүсгэлд үндэслэн хичээллэдэг клуб/ дугуйлан							
			Өсвөрийн аврагч		Өсвөрийн цагдаа / сэргийлэгч		Өсвөрийн улаан загалмайч		Эко клуб	
			Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Завхан	25			14	56%	12	48%	23	92%
2	Архангай	15			6	40%	10	67%	10	67%
3	Булган	21	2	10%	9	43%	7	33%	13	62%
4	Хэнтий	21	5	24%	11	52%	10	48%	15	71%
5	Хөвсгөл	23	1	4%	12	52%	16	69%	21	91%

² Disaster Risk Reduction in School Curricula: Case Studies from Thirty Countries, UNICEF, 2012

³ Д.Сэржмядаг нар., (2015) “Гамшгаас хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй клуб, дугуйлангуудын өнөөгийн байдал” судалгааны тайлан, Дэлхийн зөн Монгол ОУБ, Баруун аймгуудын гамшгийн эрсдэлийг бууруулах төсөл

6	Баянхонгор	27			18	67%	12	44%	27	100%
7	Улаанбаатар	63	13	21%	22	35%	39	62%	54	86%
8	Говь-Алтай	21	5	24%	13	62%	16	76%	21	100%
Нийт тоо		216	26		105		127		175	
Дундаж хувь				10%		51%		56%		84%

Өсвөрийн аврагч клуб байгуулахад учирч болох хамгийн том саад, бэрхшээлийг санал асуулганд оролцогсод санхүү, хөрөнгө мөнгө, сургалтад хэрэглэх сургалтын хэрэглэгдэхүүн гарын авлага, материал, техник хэрэгсэл, анги танхим, клубийг удирдах багш хүрэлцээгүй гэсэн нийтлэг хүндрэлийг дурдсан байна.

Аюулгүй амьдрах ухааны боловсролыг олгох үйл ажиллагааг сайжруулах арга зам

Ерөнхий боловсролын сургуульд аюулгүй амьдрах ухааны боловсролыг үр дүнтэй олгохын тулд үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүргийн байгууллагууд хүүхэд, өсвөр үеийнхэнд аюулгүй амьдрах ухааны боловсрол эзэмшүүлэх, эх оронч сэтгэлгээг хөгжүүлэх чиглэлээр явуулж буй үйл ажиллагаагаа нэгтгэх, түншлэх нь ихээхэн чухал байна.

Аливаа түншлэл нь байгууллага бие даан шийдэх боломжгүй асуудлын шийдлийг олох, туршлага, нөөцөө хуваалцах, нийтлэг тулгарч буй үйлчилгээний доголдлыг арилгах, харилцан соёл, туршлагаасаа суралцах боломжийг оролцогч талуудад олгоно. Энэ утгаараа хүүхэд, өсвөр үеийнхэнд аюулгүй амьдрах ухааныг эзэмшүүлэх нийтлэг зорилгоо хэрэгжүүлэх оновчтой арга зам нь холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын түншлэл юм.

Өсвөрийн эх орончид бүлгэмийн туршлага

Аюулгүй амьдрах ухааны боловсролыг олгох арга замыг сайжруулахын тулд МУЗН-ээс санаачлан Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 47 дугаар сургууль дээр хичээллэж буй ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад аюулгүй амьдрах ухааны боловсрол эзэмшүүлэх, эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх зорилготой "Өсвөрийн эх орончдын бүлгэм"-ийн туршлагыг улс орон даяар түгээн дэлгэрүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Өсвөрийн эх оронч бүлгэм нь "ЗОРИГ НЭГ, ЗОРИЛГО НЭГ, ЗҮТГЭЛ НЭГ-БИД ӨСВӨРИЙН ЭХ ОРОНЧИД" гэсэн уриатай бөгөөд тус бүлгэм нь дотроо

- Өсвөрийн аврагч бүлэг
- Өсвөрийн сэргийлэгч бүлэг
- Өсвөрийн зохицуулагч бүлэг
- Өсвөрийн энхийг сахиулагч бүлэг
- Өсвөрийн улаан загалмайч бүлэг гэсэн 5 бүлэгтэй дараах зорилготойгоор хичээллэдэг байна.

2-р хүснэгт. Өсвөрийн эх орончид бүлгэмийн зорилго

Бүлгийн нэр	Бүлгийн зорилго
Өсвөрийн аврагч	Гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах болон аврах ажиллагааны анхан шатны мэдлэгтэй болох, болзошгүй ослын үед өөртөө болон бусдад тусламж үзүүлэх, олж авсан мэдлэг, чадвараа бусдад эзэмшүүлэх

Өсвөрийн сэргийлэгч	Хууль, эрх зүйн мэдлэгтэй болох, цэрэгжилч жагсаалч байдлыг сурах, сургуулийн орчинд дэг журам сахиулах
Өсвөрийн зохицуулагч	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль, Замын хөдөлгөөний дүрэм, журмын анхан шатны мэдлэгтэй болох замын хөдөлгөөнд аюулгүй оролцох дадал чадвар эзэмших, олж авсан мэдлэг, чадвараа бусдад эзэмшүүлэх
Өсвөрийн энхийг сахиулагч	Эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх, эх орон, эх түүх, эр цэрэг, ээж, аав, эмээ, өвөөгийнхөө туулж өнгөрүүлсэн эгэлгүй баатарлаг үйл хэрэг, энэ цагийн энхийг сахиулах үйлсэд хүчин зүтгэж буй ах, эгчээрээ бахархах хүмүүжлийг олгох
Өсвөрийн улаан загалмайч	Олон улсын хүмүүнлэгийн хөдөлгөөнийг сурталчлах, Улаан загалмайгаараа бахархах, анхны тусламжийг үзүүлж сурах, хүүхэд залуучуудыг хүмүүнлэгийн үйлсэд татан оролцуулах,

Дээрх зорилгуудаас харахад Өсвөрийн эх орончид бүлгэм нь хүүхдийн эвсэн нэгдэх, сурч боловсрох, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангасан, хичээлээс гадуурх сургалт, хүмүүжлийн ажил гэдгээрээ аюулгүй амьдрах ухааны боловсролыг олгох албан ёсны сургалтын хөтөлбөргүй байгаа өнөө үед энэ чиглэлээр боловсрол олгох хамгийн оновчтой арга зам гэсэн дүгнэлтэд хүрч болно. Иймд тус бүлгэмийн хичээлийн хөтөлбөрт шинжилгээ хийж, хоорондын уялдаа холбоог хангах, сайжруулах талаар холбогдох мэргэжлийн байгууллагаас анхаарч ажиллах шаардлагатай байна.

Ийнхүү Аюулгүй амьдрах ухааны боловсролыг олгох чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага хоорондын түншлэл нь өмнө тодорхойлсон Өсвөрийн аврагч бүлэг байгуулахад учирч байгаа санхүү, хөрөнгө мөнгө, сургалтад хэрэглэх сургалтын хэрэглэгдэхүүн гарын авлага, материал, техник хэрэгсэл, анги танхим, бүлгийг удирдах багш хүрэлцээгүй гэсэн нийтлэг хүндрэлийг арилгах боломж бүрдэнэ.

Дүгнэлт, зөвлөмж

Дэлхийн улс орнууд албан ба албан бус хөтөлбөр (хичээлээс гадуурх нэмэлт хөтөлбөр)-өөр аюулгүй амьдрах ухааны боловсролыг олгож байна. Манай улсад өнөөдрийг хүртэл аюулгүй амьдрах ухааны боловсрол олгох сургалт ерөнхий боловсролын сургуулийн албан ёсны сургалтын хөтөлбөрт ороогүй байгаа юм. Иймд хүүхэд, өсвөр үеийнхэнд аюулгүй амьдрах ухааны боловсролыг хэрхэн олгох вэ гэдэг асуудал бидний өмнө тулгарч байна. Судалгаанаас харахад аюулгүй амьдрах ухааны боловсролыг хичээлээс гадуурх нэмэлт хөтөлбөрөөр олгох боломж байна.

Аюулгүй амьдрах ухааны боловсролыг хичээлээс гадуур нэмэлт хөтөлбөрөөр олгох Өсвөрийн аврагч бүлгийн үйл ажиллагаа дөнгөж эхлэлийн төдий байгаа ч, энэ чиглэлээр сайн туршлага манай улсад аль хэдийн бий болжээ. Өсвөрийн аврагч бүлгийг дангаар нь хичээллүүлэхийн оронд Өсвөрийн эх орончид бүлгэмийг байгуулж үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй байгууллагууд хамтарч ажиллах нь үр дүнтэй арга зам гэж үзэж байна. Иймд энэхүү арга хэлбэрийг улам боловсронгуй болгож, бусад ерөнхий боловсролын сургуулиудад нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах хэрэгтэй. Түүнчлэн, Өсвөрийн эх орончид бүлгэмийг

тогтвортой ажиллуулахын тулд:

- Бүлгэмийн үйл ажиллагаагаар дамжуулж олон нийтэд аюулгүй амьдрах боловсрол олгох ажлыг амжилттай зохион байгуулсан, үе тэнгийнхэндээ сайн үлгэр дууриал үзүүлсэн, онцгой гавъяа байгуулсан бүлгийн гишүүн сурагчдад олгох тусгай тэмдэг бий болгох, бүлгийн гишүүдэд зэрэг, дэв олгох зэргээр хүүхдүүдийг урамшуулах, бүлэгт хамрагдах сэдлийг төрүүлэх
- Өсвөрийн эх орончид бүлгэмийн үйл ажиллагааг амжилттай сайн зохион байгуулсан төгсөх ангийн сурагчдыг ХСИС-д элсэлтийн шалгалтгүйгээр эсвэл хөнгөлттэй нөхцлөөр элсүүлэх нөхцлийг бүрдүүлэх
- Өсвөрийн эх орончид бүлгэмийн үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр (сонин, сэтгүүлд тодорхой булан бий болгох) сурталчилах
- Өсвөрийн эх оронч бүлгэмийг хичээллүүлсэн нийгмийн ажилтан бусад багшийг урамшуулах арга замыг тодорхойлох шаардлагатай.

Эх сурвалжийн жагсаалт

1. Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003
2. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, 2011
3. Д.Сэржмядаг нар., (2015) "Гамшгаас хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй клуб, дугуйлангуудын өнөөгийн байдал" судалгааны тайлан, Дэлхийн зөн Монгол ОУБ, Баруун аймгуудын гамшгийн эрсдэлийг бууруулах төсөл
4. Тони Бовэйрд, Элке Лөйффлер (2014), Улсын салбарын менежмент, засаглал, Лондон
5. UNICEF (2012). Disaster Risk Reduction in School Curricula: Case Studies from Thirty Countries, Geneva